ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 10 сарын 16 өдөр Дугаар 128 Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай

Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 9.8 дахь заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5^1 дүгээр зүйлийн $5^1.1.8$ дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Тусгай зөвшөөрлөө хүчингүй болгох талаар гаргасан хүсэлтийнх нь дагуу "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн Орхон аймгийн Баян-Өндөр сум, Өвөрхангай аймгийн Төгрөг, Уянга, Хужирт сум, Өмнөговь аймгийн Ноён, Ханбогд, Даланзадгад сум, Сэлэнгэ аймгийн Мандал сум, Улаанбаатар хотын Багануур дүүргийн нутаг дэвсгэрт Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах /Утасгүй интернэт/ 23700030 дугаар тусгай зөвшөөрлийг хүчингүй болсонд тооцсугай.

2.Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон шийдвэрийг өөрт нь болон зөвшөөрөл эзэмшигчийн харьяалах татварын албанд мэдэгдэх, холбогдох өөрчлөлтийг мэдээллийн нэгдсэн санд оруулах арга хэмжээ авч ажиллахыг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /З.Эрдэнэчулуун/-т, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус хорооны дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д тус тус даалгасугай.

ДАРГА Ж.БАТ-ЭРДЭНЭ

ГИШҮҮД Ь.АНХЬААТАР

Ц.ГАНЗОРИГ

Б.ДАГВАСҮМБЭРЭЛ

Ч.ЗОЛБАЯР

С.ТАМИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР